

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫГ БИЙ БОЛГОХ ШААРДАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ

Г.Бурмаа\* О.Уянга\*\*

**Хураангуй:** Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, хүмүүсийн зохисгүй зарим үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх гамшгаас учрах хохирол манай оронд төдийгүй дэлхий дахинд улам бүр нэмэгдэж байна.

Одоогийн байдлаар зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниуд нь ихэвчлэн ердийн даатгалын үйл ажиллагааг явуулж байгаа төдийгүй хууль эрх зүйн хувьд ч гамшгийн эрсдэлээс сэргийлэх болон олныг хамарсан хүртээмжтэй даатгалын хуулийн зохицуулалт төдийлөн боловсруулагдаагүй байна. Энэ сэдвийн хүрээнд Монгол улсад үүсч болох гамшгийн эрсдэлийг тодорхойлох, бууруулах арга хэмжээг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийн даатгалыг бий болгох боломж, арга замыг судалсан болно.

**Түлхүүр үгс:** Гамшгийн эрсдэл, гамшгийн эрсдэлийн менежмент, гамшгийн эрсдэлийн даатгал, газар хөдлөлтийн даатгал

**Abstract:** The impact of climate change, global warming and some of the unwelcoming actions of human beings is increasing in our country and global.

Currently insurance companies operating in the financial market have the non life insurance business, also they are not well developed regulation on prevention of disaster risk insurance and multiple inclusive insurance. In this context, we are exploring the possibility of identifying and mitigating the disaster risk in Mongolia and building a disaster risk insurance.

**Key words:** Disaster risk, Disaster risk management, Disaster risk insurance, Earthquake insurance

---

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) fin\_burmaa@yahoo.com

\*\* МУИС-ийн Бизнесийн сургууль

### Гамшгийн эрсдэлийн даатгалыг хэрэгжүүлэх шаардлага, тулгамдсан асуудлууд

Аюул осол, эрсдэл хүн төрөлхтний түүхийн бүхий л үеийн турш хамт оршиж бодит хохирол учруулсаар ирсэн ба ялангуяа гамшгийн эрсдэл нь хүний амь нас, өмч хөрөнгө болон бүтээж бий болгосон материаллаг баялагт асар их хэмжээний хохирол учруулсаар иржээ.

Эрсдэлийг “ердийн” болон “онцгой буюу гамшгийн” эрсдэл гэж ангилж үзэх ба “Ердийн эрсдэл” гэдэгт ердийн болон амьдралын даатгалын гэрээгээр даатгагч хариуцах эрсдэлийг “Онцгой эрсдэл” гэдэгт ердийн эрсдэлд хамаарагдахгүй, эрх бүхий байгууллагаас тодорхойлж даатгалын гэрээнд тусгасан нэмэлт эрсдэл буюу:

- Байгалийн онц аюултай үзэгдэл газар хөдлөлт, их хэмжээний үер, хэт хүйтрэл, маш хүчтэй салхи
- Техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, бослого, эмх замбараагүй байдал, дэлбэрэлтийн эрсдэлийг багтааж үзнэ.

“Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгал” гэж онцгой эрсдэлээс үүдэлтэй санхүүгийн хохирлыг барагдуулах зорилготой даатгалыг хэлнэ.

Гамшгийн эрсдэлийг учирч болох хэлбэр, байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас хамаарсан байдлаар дараах төрөл, хэлбэрт ангилж үзнэ.

| Гамшгийн ангилал                           | Гамшгийн төрөл                 | Гамшгийн хэлбэр                  |
|--|--------------------------------|----------------------------------|
| Байгалийн аюул                             | Цаг агаарын аюулт үзэгдэл      | Цасан шуурга                     |
|  |                                | Их цас                           |
|  |                                | Зуд                              |
|  |                                | Шороон шуурга                    |
|  |                                | Үер                              |
|  |                                | Ой, хээрийн түймэр               |
|  |                                | Ганцөлжилт                       |
|  | Геологийн аюулт үзэгдэл        | Аянга                            |
|  |                                | Газар хөдлөлт                    |
|  |                                | Хөрсний гулсалт                  |
| Биологийн аюулт үзэгдэл                    | Хортон шавьж тархах            |                                  |
|  | Олон улсын хөл хориот өвчин    |                                  |
|  | Мал, амьтны гоц халдварт өвчин |                                  |
| Хүний үйл ажиллагаатай холбоотой аюул осол | Технологийн аюул осол          | Үйдвэрийн осол                   |
|  |                                | Тээврийн хэрэгслийн осол, сүйрэл |
|  |                                | Цацраг химийн бодисийн алдагдал  |
|  |                                | Дэлбэрэлт                        |
|  |                                | Объектын түймэр                  |

Эх сурвалж: Монгол Улсын “Гамшгаас хамгаалах тухай хууль”

2017 оны Монгол Улсын стандарт MNS ISO 31010-д зааснаар “Гамшгийн эрсдэлийн менежментийн үйл ажиллагаа нь эрсдэлийг тодорхойлох, бууруулах, бэлэн байдлыг хангах, санхүүгийн арга механизм ашиглан эрсдэлээс хамгаалах, тогтвортой сэргээн босгох зэрэг 5 үндсэн үе шатаас бүрддэг байна.



Эх сурвалж: Монгол Улсын стандарт MNS ISO 31010,2016

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний арга:

$$R = (H * V) / C$$

$R$  – эрсдэлийн зэрэг

$H$  – аюулын зэрэг

$V$  – эмзэг байдлын зэрэг

$C$  – чадавхийн зэрэг



Эмзэг байдлын үнэлгээг хийхдээ:

Хүн ам болон тэдгээрийн амьдрах орчин гамшигт өртөх магадлал, хүн амын бүтэц, тэдгээрийн тархалт, суурьшил, дэд бүтцийн хөгжил, барилгын стандарт болон ашиглалтын хугацаа, эдийн засгийн чадавхи, шашин шүтлэг, уламжлалт ёс заншил, байгаль орчин, түүний өртөмтгий чанар зэргийг харгалзан үзнэ.

Гамшигтай тэмцэх чадавхийн үнэлгээг хийхдээ:

Гамшгийн талаархи хууль тогтоомж, хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоо, гамшгийн бэлэн байдал, гамшгаас хамгаалах төлөвлөлт, гамшгийн аюулыг бууруулах цогц арга хэмжээ, зарлан мэдээлэл, прогнозчиллын систем, сурталчилгаа, мэдээллийн систем, түүний үйл ажиллагаа, нөөц хөрөнгө, хүн амын идэвхи оролцоо, хүн амын дунд хийгдсэн сургалт, түүний түвшин зэргийг харгалзан үнэлнэ.

Эрсдэлийн үнэлгээг хийхдээ:


Болзошгүй аюулаас үүсч болох хохирлын магадлалыг тогтоох ба эрсдэлийг үүсгэж болох хөнөөлт хүчин зүйл тухайн нутаг дэвсгэрт үүсэх магадлал, хүн ам болон байгаль орчинд эрсдэл учруулах тодорхой нөхцөл бүрэлдэх магадлал, үүссэн эрсдэлээс хүн ам, байгаль орчинд хохирол учрах магадлал, учирч болох эрсдэлийн түвшин буюу хүн ам, хүрээлэн байгаа орчинд эрсдэл учрах магадлал зэргийг тодорхойлно.

Аюулын үнэлгээг хийхдээ:

Тухайн нутагт дэвсгэрт тохиолдож болзошгүй аюулт үзэгдлийг тогтоож, эрсдэлийн түвшингээр нь зэрэглэн ангилж, эрсдэлийг бууруулах хувилбаруудыг гаргах ба аюулт үзэгдлийн шинж чанар, түүний тохиолдох давтамж, учруулж болзошгүй хохирол, тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн аюулыг гэтлэн давах чадвар, тухайн аюулт үзэгдлийн талаар урьд нь хийсэн судалгаа, бүрдгэл байгаа зэргийг тогтооно.

Дэлхийн хэмжээгээр 1970 оноос хойш сүүлийн 40 жилд тохиолдсон топ 15 тохиолдол бүгд 1990 оноос хойш бүрдгэгдсэн ба үүний 10 нь 2005-2015 оны хооронд бүрдгэгджээ. Дэлхий дахинд гамшгаас учрах хор хохирол өсөн нэмэгдэж, олон мянган хүн амь нас, эд хөрөнгөө алдаж, гэмтэж бэртэн, улс орнуудын аюулгүй байдал, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хөгжил, хүн амын сайн сайхан амьдралд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тухайлбал 2005-2015 онд 700 мянга гаруй хүн амь насаа алдаж, 1,4 сая хүн гэмтэж 23 сая орчим хүн гэр оронгүй болж, эдийн засгийн хохирлын хэмжээ 1,3 их наяд ам.долларт хүрчээ. (UNISDR, 2015)

Зураг1. 1970-2015 онуудад хамгийн өндөр даатгагдсан хохирлууд:  
Тэрбум ам.доллар



Эх сурвалж: Fact book of Insurance Information Institute

Манай орны хэмжээнд байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн осол, гамшгийн тоо, давтамж, түүнээс учирсан хохирлын хэмжээ улам бүр нэмэгдсээр байна. Нөгөөтэйгүүр манай улсад гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоо бүрдээгүйн улмаас гамшгийн хохирлыг төр хариуцах, улсын төсөвт дарамт учруулах асуудал тулгарсаар байгаа юм.

Дэлхий нийтэд түгээмэл тохиолддог байгалийн аюулт үзэгдлээс манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, хуй салхи, цөлжилт, аянга, аадар бороо, үер, хүн, малын олон улсын хөл хориот гоц халдварт өвчний тархалт зэрэг байгалийн гаралтай аюулт үзэгдэл, осол гарч, хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин сүйрч, нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учирч байна.

Монгол улсад сүүлийн 10 жилийн байдлаар нийт 46,852 жилд дунджаар 4,685 гамшигт үзэгдэл бүрдгэгдсэнээс:


- 66.5% нь ой хээрийн болон объектын түймэр,
- мал хорогдсон тохиолдол 25%,
- хүний амь нас эрсэдсэн тохиолдол 4,8%,
- цасан болон шороон шуурга 0,5%,
- аадар бороо үерийн аюул 0,5%-ийг эзэлж байна.

Хүснэгт 1. Аюулт үзэгдэл, ослын тоо, хохирлын хэмжээ  
/Сүүлийн 3 жилийн байдлаар/

| Гамшигт үзэгдэл, хохирол                                 | 2016    | 2015    | 2014    |
|--|---------|---------|---------|
| Гамшигт үзэгдлийн тохиодлын тоо                          | 4381    | 5426    | 4926    |
| Ой, хээрийн түймэр /тоо/                                 | 138     | 354     | 281     |
| Шатсан ой, хээр /сая га/                                 | 6       | 5       | 2.1     |
| Объектын түймэр /тоо/                                    | 3710    | 4561    | 4222    |
| Хүчтэй цасан болон шороон шуурга /тоо/                   | 14      | 21      | 25      |
| Аадар бороо, үерийн аюул /тоо/                           | 21      | 49      | 32      |
| Хорогдсон, устгасан мал, амьтан /мян.толгой/             | 1059388 | 202929  | 15128   |
| Гамшгийн улмаас нас барсан хүн /тоо/                     | 230     | 198     | 175     |
| Гамшгийн улмаас учирсан хохирлын хэмжээ /<br>тэрбум төг/ | 43073.6 | 79951.8 | 25164.3 |


2017 оны эхний 8 сарын байдлаар тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тоо, хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Зураг 2. Аюулт үзэгдэл, ослын тоо, хохирлын хэмжээ:



Эх сурвалж: ОБЕГ-ын мэдээ 2017

Зураг 3: Аюулт үзэгдлийн улмаас нас барсан болон гэмтэж бэртсэн хүний тоо:



Эх сурвалж: ОБЕГ-ын мэдээ 2017

**Монгол Улсад гамшгийн эрсдэлийн даатгалыг хэрэгжүүлэх боломж**

2017 оны “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 34.2.5д “Аж ахуйн нэгж байгууллагууд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, холбогдох даатгалд хамрагдахшаардлагатайг тусгажээ.

Монгол орон газар орны онцлог, уламжлалт аж ахуй, эдийн загийн байдлаас хамаарч одоогийн байдлаар байгалийн болон геологийн учирч болох эрсдэлээс хамгаалсан 3 төрлийн даатгалд хамруулах боломж байна.

**Малын индексжүүлсэн даатгал**

Монгол улс 2005 оноос Дэлхийн банкны тусламжтайгаар дэлхийд анх удаа малыг индексжүүлэн даатгах төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Уг төслийг 2012 оноос үндэсний хэмжээнд бүрэн хамруулж, 2014 онд малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг УИХ-аар баталж, Хөдөө аж ахуйн үндэсний давхар даатгалын компанийг байгуулснаар малыг гамшгийн эрсдэлээс даатгах болсон.

#### Газар тариалангийн даатгал

Монгол улсын газар тариалангийн нийт бүтээгдэхүүний 60 хувийг дангаар эзэлж буй улаан буудайг туршилтын журмаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Хүдэр сумуудад болон Төв аймгийн Цээл сумдад нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд хамруулж эхлээд байна.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудай тариалж буй этгээдийг байгаль, цаг уурын болон бусад урьдчилан сэргийлэх боломжгүй нэр бүхий эрсдэлээс шалтгаалан ургац алдах, улмаар эдийн засгийн хохирол хүлээх эрсдэлээс хамгаалах зорилготой юм. Ган, мөндөр/ аянга цахилгаан, цочир хүйтрэлт, гал, хүчтэй салхи, шороон шуурга, үргэлжилсэн бороо, үер зэрэг тодорхой гамшигт эрсдэлүүдээс даатгана.


#### Газар хөдлөлтийн даатгал

1945 оны хүчтэй газар хөдлөлтийн дараа байгуулагдсан Газар хөдлөлтийн зөвлөлөөр дамжуулан Шинэ Зеланд Улсын Засгийн газар айл өрхийн заавал даатгах газар хөдлөлтийн даатгалын хөтөлбөрийн хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү даатгалд газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, цунами зэрэг газар зүйн холбогдолтой аюулын даатгалууд багтсан. 2011 оны газар хөдлөлтийн өмнө \$5.93 тэрбум (MNT10.2 их наяд)—н хөрөнгө даатгуулсан байсан.

Давхар даатгалыг гадаадын даатгалын компаниар дамжуулан явуулдаг. 2011 оны газар хөдлөлтийн дараа оршин суугчдын даатгуулсан \$3 тэрбум-ын хөрөнгө даатгалаас эргэн төлөгдөх болсон.

Хятад, Энэтхэг, Япон, Шриланк, Тайланд зэрэг 10 улс оронд гамшигийн эрсдэлийн даатгалтай бөгөөд эдгээрийг Засгийн газар болон хувийн хэвшил нь хариуцдаг байна.

Сүүлийн жилүүдэд УБ хот болон түүний орчимд газар хөдлөлтийн идэвхжил нэмэгдсээр байна.



Эх сурвалж: ОБЕГ-ын мэдээ 2017

Сүүлийн 50 жилд болсон Улаанбаатар хотын оршин суугчдад мэдрэгдсэн хүчтэй газар хөдлөлтүүд:

1957 онд 650 км зайд орших Говь-Алтайн нурууны Их Богдод болсон  $M > 8$

1967 онд Булган аймгийн Могодын  $M > 7$  /300 км/

1979 онд Сэлэнгэ аймгийн Бүтээлийн нурууны  $M > 6$  /280 км/

1998 онд Дундговь аймгийн Дэрэнгийн  $M > 6$  /180 км/

2005 онд Төв аймгийн Зүрх ууланд  $M > 5$

2006 онд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум Бүтээлийн нуруунд  $M > 5.2$

2006 онд Өвөрхангай аймгийн Арц Богд уул  $M > 5.9$

2006 онд Говь-Алтай аймгийн Гичгэний нуруу  $M > 6.6$

2008 онд Байгаль нуурийн орчим  $M > 6.1$  /463 км/

2010 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сум  $M > 5.6$

2011 онд ОХУ-ын Буриад улс, Татарск,  $M > 5.0$


2011 онд Өмнөговь аймаг, Ханхонгор сум,  $M > 5.8$

2012 онд ОХУ-ын Тува улс, Кызыл хот,  $M > 6.8$

Нийслэлийн Захирагчийн ажлын албаны гаргасан судалгаагаар Улаанбаатар хотын нийт 92300 барилгын бүрдгэлээс газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн шаардлага хангаагүй барилга Сонгинохайрхан дүүрэгт 19, Баянзүрх дүүрэгт 65, Хан-Уул дүүрэгт 69, Сүхбаатар дүүрэгт 65, Чингэлтэй дүүрэгт 54, Налайх дүүрэгт 30 нийт 302 барилга байна. Барилга хүлээн авах Улсын комиссын



шийдвэргүйгээр ашиглалтанд оруулсан 100 гаруй барилга байна.



Эх сурвалж: ОБЕГ-ын мэдээ 2017

Олон улсад болон манай оронд хэрэглэж байгаа газар хөдлөлтийн хохирлыг урьдчилан тооцож, үнэлэх аргачлалаар нийслэл хотод  $M < 7$  ба түүнээс дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт болоход 300-550 орчим барилга, орон сууц эвдэрч, гэмтэл учиран 30-60 орчим мянган хүний эрүүл мэнд, амьдралын хэвийн нөхцөл алдагдаж болзошгүй тооцоог гаргасан байна.

Иймд “Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгал”-д хүн амыг өргөнөөр хамруулах, тэдгээрийн амьдарч буй барилга, орон сууцныг эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Олон улсын туршлагаас харахад “Гамшгийн эрсдэлийн даатгалыг” төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор хэсэгчилсэн албадлагын шинж чанартай хэрэгжүүлдэг байна. Төрийн оролцооны хувьд “Гамшгаас хамгаалах сан”-г бүрдүүлэх шаардлагатай ба төрийн өмчийн оролцоотой давхар даатгалын компаниар дамжуулж гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалыг бий болгох боломжтой юм.

Манай улсын хувьд хувийн даатгалын компаниудад хийгдэж байгаа хөрөнгийн болон амь насны даатгалын гэрээний нөхцөлд нэмэлт хэлбэрээр гамшгийн эрсдэлийг тусгаж гамшгаас хамгаалах эрсдэлийн даатгалыг хэрэгжүүлэх боломж байна.

- Орон сууцны даатгал
  - Хөрөнгийн даатгалын гэрээгээр ердийн даатгалын гэрээ ба гамшгийн даатгалын гэрээ нэгэн зэрэг хүчин төгөлдөр болно.
  - Ердийн даатгалын хураамжийг тухайн даатгагч, гамшгийн даатгалын

хураамжийг Гамшгийн даатгалын сан хариуцаж гэрээний дагуу тус тус үүрэг хүлээнэ.

## 2. Зээлдэгчийн амь насны даатгал

- Хугацаат амьдралын даатгалын гэрээгээр зээлдэгчийн амь насны даатгалын гэрээ ба гамшгийн даатгалын гэрээ нэгэн зэрэг хүчин төгөлдөр болно.
- Амьдралын даатгалын хураамжийг тухайн даатгагч, гамшгийн даатгалын хураамжийг Гамшгийн даатгалын сан хариуцаж гэрээний дагуу тус тус үүрэг хүлээнэ.

## 3. Мал аж ахуй, газар тариалангийн давхар даатгал

- ХАА-н давхар даатгалтай холбоотой үйл ажиллагааг төрийн өмчийн оролцоотой давхар даатгалын компани хариуцан зохион байгуулна. Төрийн өмчийн оролцоотой давхар даатгалын компани нь дараах чиг үүргүүдийг гүйцэтгэнэ.
- Гал, түймэр, гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд оролцогчийн эрүүл мэнд, амь насны даатгалыг албан журмын бие даасан бүтээгдэхүүн гаргах
- ХАА давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх
- ГЭХД-ын давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх  
Төрийн зүгээс хэрэгжүүлэх шаардлагатай чиг үүрэг:
- Гамшгийн даатгалын нэмэлт хураамжийг тооцож СЗХ-оор хянуулан тогтоох
- Онцгой эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх
- Ослоос урьдчилан сэргийлэх, сурталчлан таниулах, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө ба хөтөлбөр боловсруулах

## Дүгнэлт

Монгол орон эрс тэс уур амьсгалтай эрсдэл ихтэй, ихээхэн эмзэг бүс нутагт оршдог. Түүхэн баримтаас үзэхэд манай улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан болон хэсэгчилсэн аюулт үзэгдэл, осол эртнээс нааш аливаа хэлбэрээр нүүрлэсээр ирсэн төдийгүй сүүлийн жилүүдэд урьд өмнө нь гарч байгаагүй аюулт үзэгдэл, осол тохиолдох болсон. Үүний улмаас хэдэн зуун хүн амь насаа алдаж, эд материал, сэтгэл санааны хохирол амсаж байгаагийн зэрэгцээ гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд асар их хөрөнгө зарцуулж улс орны эдийн засгийн хөгжилд багагүй дарамт болж байгаа юм.

УИХ-ын 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэлийн 2.3-т “Гамшгийн нэр томъёоны ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрхзүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай” гэж заасан нь “Гамшгийн эрсдэлийн даатгал”-ыг бий болгох, уг даатгалын хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

“Гамшгийн эрсдэлийн даатгал”-ыг хэрэгжүүлснээр гамшигт үзэгдлийн улмаас төрийн, орон нутгийн, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөнд учирсан хохирлын дийлэнх хэсгийг даатгалын хөрөнгөөр нөхөн төлөх боломж бий болох бөгөөд ингэснээр гамшгийн хор хохирлыг богино хугацаанд нийгэм, эдийн засагт хохирол багатайгаар арилгах, гамшгийн үр дагаврыг даван туулах боломж бүрдэх юм.

Гамшгийн эрсдэлийн даатгалыг хэргжүүлэхэд эхний ээлжинд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- “Гамшгийн даатгалын тухай хууль” боловсруулж, батлан гаргах
- Гамшгийн даатгалын тухай хууль батлагдан гарснаар гамшигт үзэгдлийн улмаас төрийн, орон нутгийн, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөд учирсан хохирлын дийлэнх хэсгийг даатгалын хөрөнгөөр нөхөн төлөх боломж бий болох, Гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоог бусад улс орнуудын адилаар Монгол улсад бийболгож, нэвтрүүлэх бүрэн бололцоотой болох юм.
- “Төрийн өмчийн оролцоотой давхар даатгалын компани” байгуулах 2015 онд манай улсад “ХАА-н үндэсний давхар даатгалын компани” байгуулсан нь гамшгийн эрсдэлийн даатгалыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох юм.
- “Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгалын сан” байгуулах.

Гамшгийн даатгалын үйл ажиллагааг төрөөс хянах, зохицуулах шаардлагатай. Энэ чиг үүргийг Санхүүгийн захицуулах хороо, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хэрэгжүүлнэ.

**Ашигласан материал**

1. Principles of risk management and insurance, George R.Rejda, Micheal J.McNamara-Twelfth edition, 2014
2. “Газар хөдлөлтийн даатгалын шинэ бүтээгдхүүний судалгаа”, Б.Заяа, Тэнгэр даатгал, 2010
3. “Гамшгийн эрсдэлийн даатгалыг хэрэгжүүлэх хэрэгцээ, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал”, Үндэсний форум, 2017 он
4. “Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга”, 2017 он
5. “Гамшгийн эрсдэлийн даатгал”-ын гарын авлага, ГХАН/GIZ/ 2017 он
6. УИХ, “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, 2011 он
7. УИХ, “Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, 2006 он
8. Монгол улсад тохиолсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл, Д. Бадамсүрэн 2017 он
9. Геологи, одон орон судлалын төв/ Газар хөдлөлтийн судалгаа/  
[www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn)  
[www. Factbook of International insurance institute](http://www.FactbookofInternationalinsuranceinstitute.com), 2016